

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 11 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 263

Улаанбаатар хот

Арилжааны хэлцэл хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.6, Иргэний хуулийн 56.1.10, 107.2, 475.2, 498.1 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 17.2, 19.2.8, 27.3.2, 34.1.11 дэх заалт, Үнэт цаасны хорооны 2003 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчээс үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай журам”-ын 3.1.1, 3.1.2, 3.1.4, 3.1.6 4.3.3, 4.3.4, 4.3.5, 4.3.9, Үнэт цаасны хорооны 2003 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Харилцагчийн захиалгыг хүлээн авах, биелүүлэх тухай журам”-ын 3.4, 6.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хавсралтад дурьдсан нэр бүхий 23 иргэний өмчлөлд байсан хувьцааг тэдний зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар арилжаалсан нийт 72 хэлцлийг хүчингүй болгосугай.

2. “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь хавсралтад дурьдсан нэр бүхий 23 иргэний дансанд хууль бусаар арилжигдсан хувьцааг буцаан бүртгэж, тогтоолын 3-т заасан этгээдүүд үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, шударга зэмшигчийн хохирлыг барагдуулсан тухай бүр Хороонд албан ёсоор мэдэгдэж ажиллахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Г.Гандулам/-д үүрэг болгосугай.

3. Иргэн Б.Батмөнхийн 29-602616, Ж.Баттөрийн 7-887341, Х.Энхжаргалын 17-888825, С.Өлзийхишигийн 19-228299, К.Романовскийн 7-610445 тоот төвлөрсөн хадгаламжийн дансуудад зохих хөрөнгийг 12 дугаар сарын 19-ний өдрийн дотор байршуулан Хороонд албан ёсоор эргэж мэдэгдэхийг “Мөнхөд” ХХК /Г.Баасангарав/-д, иргэн Д.Бат-Эрдэнийн 14-506, К.Романовскийн 7-610445, Р.Зоригтбаатарын 14-401006, “Ээрмэл” ХК-ийн 27-1195, Б.Нямтайширийн 31-2502 тоот төвлөрсөн хадгаламжийн дансуудад зохих хөрөнгийг 12 дугаар сарын 19-ний өдрийн дотор байршуулан Хороонд албан ёсоор эргэж мэдэгдэхийг “Ажнай инвест” ХХК /Д.Ганболд /-д тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шударга эзэмшигчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах үүднээс тэдэнд холбогдох мэдээллийг хүргэж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ